



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 -р сарын 20 -ны өдөр

№ А/37 Т

Улаанбаатар хот

*Компанийн 2020 оны Бизнес төлөвлөгөө,
Бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дах заалт болон “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9.6.7, 9.6.8 дах заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны “Санхүүгийн төлөвлөгөө”-г Нэгдүгээр хавсралт, “Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г Хоёрдугаар хавсралт, “Орон тооны төлөвлөгөө”-г Гуравдугаар хавсралт, “Зээлийн багцийн төлөвлөгөө”-г Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай;
2. Компанийн шинэчилсэн Бүтэц, зохион байгуулалтыг Тавдугаар хавсралтаар баталсугай;
3. Шинэ бүтэц, зохион байгуулалт болон орон тооны дагуу холбогдох албан тушаалтнуудыг томилж, чөлөөлж, өөрчлөлт оруулахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д үүрэг болгосугай;
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 -р сарын 20 -ны өдөр

№ 8/38-Т

Улаанбаатар хот

Үнэт цаас хаалттай хүрээнд гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь заалтууд, 82 дугаар зүйлийн 82.2.4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.5 дахь хэсгүүд, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, “Монголын Үнэт Цаасны Бирж” ХК-ийн Биржийн бус зах зээлд үнэт цаас бүртгэх журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.10 дахь хэсгүүд, мөн зүйлийн 2.1.(1) дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсгүүд, 9 дүгээр зүйлийн 9.6.5, 9.6.11, 9.6.22 дахь заалтууд болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлд тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд нийт 10,000,000,000.00 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий үнэт цаасыг нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргасугай.
2. Компанийн хаалттай хүрээнд гаргах үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах Хороо бүртгэснээс хойш 6 (зургаан) сарын хугацаанд багтааж, Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн гаргахыг дурдсугай.
3. Компанийн хаалттай хүрээнд хэсэгчлэн гаргах үнэт цаасны нөхцөлийг тухай бүрт нь Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар тогтоосугай.
4. Хаалттай хүрээнд үнэт цаас хэсэгчлэн гаргах хүрээнд Андеррейтерийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах, тус гэрээний үр дүн болон Өрийн бичгийн хөтөлбөрийн хэрэгжилийн явцыг танилцуулж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан)-д зөвшөөрсүгэй.
5. Хаалттай хүрээнд үнэт цаас хэсэгчлэн гаргахтай холбоотой судалгаа, шинжилгээ хийж, тэдгээрийн явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (А. Энэрэл)-д даалгасугай.





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 -р сарын 20 -ны өдөр

№ 140 -Т


Улаанбаатар хот

*“Зээлийн эрх нээх” гэрээний хугацааг сунгахыг
зөвшөөрөх тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт болон “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.15 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь Ко-бренд кредит картын зээлийн эх үүсвэрийг санхүүжүүлэх зорилгоор Худалдаа хөгжлийн банктai байгуулсан ЗГ/RCC171108030-2 тоот “Зээлийн эрх нээх гэрээ”-ний хугацааг уг гэрээний үндсэн хугацаагаар буюу 2 жилийн хугацаатайгаар сунгахыг зөвшөөрсүгэй;
2. Зээлийн эрх нээх гэрээний хугацааг сунгаж байгаатай холбогдуулан Худалдаа хөгжлийн банктai холбогдох гэрээ, хэлцэл байгуулах болон бусад холбогдох бичиг баримтад компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай;
3. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 -р сарын 20 -ны өдөр

№ А/41-Т

Улаанбаатар хот

*Зээлийн эрхийн хэмжээг нэмэгдүүлэхийг
зөвшөөрөх тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт болон “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.15 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь Ко-бренд кредит картын зээлийн эх үүсвэрийг санхүүжүүлэх зорилгоор Худалдаа хөгжлийн банктай байгуулсан “Зээлийн эрх нээх гэрээ”-ний дүнг 400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөгөөр нэмэгдүүлж нийт 900,000,000 (есөн зуун сая) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий зээлийн эрхийн шугамыг банкны зээлийн хорооны шийдвэрлэсэн нөхцөлөөр нээлгэхийг зөвшөөрсүгэй;
2. Зээлийн эрхийн шугамыг нэмэгдүүлж байгаатай холбогдуулан Худалдаа хөгжлийн банктай холбогдох гэрээ хэлцэл байгуулах болон бусад холбогдох бичиг баримтад компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай;
3. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б. АНХБОЛД



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 -р сарын 20 -ны өдөр

№ А/43-Т

Улаанбаатар хот

*Охин компанийн үйл
ажиллагааг эхлүүлэх тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт болон “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 9.6.19 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 327 тоот тогтоол, Компанийн ТУЗ-ийн 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/19-Т тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/37-Т тоот тогтоолын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан “2020 оны Бизнес төлөвлөгөө”-нд заасны дагуу Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай “Инвескор Хэтэвч ББСБ” ХХК -ийн үйл ажиллагааг эхлүүлж, “Покет” бичил зээлийн аппликейшн гаргахыг тус компанийн Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/ -д зөвшөөрсүгэй.
2. Дээрх Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхийг Компанийн Санхүүгийн захирал /Р.Пүрэв/-т зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 -р сарын 20 -ны өдөр

№ 1/44-Т

Улаанбаатар хот

Охин компанитай холбоотой асуудлыг шийдвэрлэх тухай

“Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9.6.19 дахь заалт, болон Иргэний хуулийн 63 дугаар зүйлийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/37-Т тоот тогтоолын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан “2020 оны Бизнес төлөвлөгөө”-нд заасны дагуу олон улсад үйл ажиллагаагаа тэлэх зорилгын хүрээнд Бүгд Найрамдах Киргиз улсад хуулийн этгээд болох “Золотой Стандарт ХХК”-ийн хувьцааг худалдан авахад шаардлагатай 1,100,000 (нэг сая нэг зуун мянган) ам.доллар хүртэлх хөрөнгө оруулахыг зөвшөөрсүгэй;
2. “Золотой Стандарт ХХК”-ийн 2020 оны Бизнес төлөвлөгөө, бүтэц, орон тоог 2020 оны 01 дүгээр улиралд багтаан гаргаж, ТУЗ-д танилцуулахыг Санхүүгийн захирал (Р. Пүрэв)-т даалгасугай;
3. Энэхүү тогтоолын хүрээнд “Золотой Стандарт ХХК”-ийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчийн бүх шийдвэрийг Компанийн нэрийн өмнөөс төлөөлөн баталгаажуулж гарын үсэг зурах эрхийг (Баянмөнхийн Анхболд)-д олгосугай;
4. Энэхүү тогтоол нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас хүчингүй болгох шийдвэр гаргах өдөр хүртэлх хугацаанд хүчинтэй байхыг тогтоосугай;
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (А. Энэрэл), болон Дотоод аудиторт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

